



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 6 сарын 26 өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

Хорооны 2019 оны 126 дугаар тогтоолын хавсралтад засвар оруулах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, Хорооны 2015 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийн 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хорооны 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан шийдвэрийн төслийг боловсруулсан албан хаагчид хариуцлага алдаж тогтоолын хавсралтад хувьцааны тоо ширхгийг алдаатай оруулсан байх тул тус тогтоолын хавсралт дахь хүснэгтийн хоёрдугаар мөрний дөрөв дэх баганад заасан “ГрэйпСити Монгол” ХХК-ийн эзэмшлийн хувьцааны тоо ширхэг “126,200,000” /нэг зуун хорин зургаан сая хоёр зуун мянга/ гэснийг “126,600,000” /нэг зуун хорин зургаан сая зургаан зуун мянга/ болгон зассугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН